

**ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ БАНК БУС
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2016 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН МЭДЭЭНИЙ
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2016.6.10 Улаанбаатар хот

НЭГ. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭНИЙ ИРЦ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалтыг үндэслэн тогтоосон “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын 10 дугаар зүйлийн 10.2-10.3 дахь хэсэгт гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй банк бус санхүүгийн байгууллагууд нь тайлант сарын гадаад валютын арилжааны мэдээг дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлж байхыг заасан. Уг заалтын дагуу гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-уудаас гадаад валютын арилжааны мэдээг сар бүр гаргуулан авч, улирлаар нэгтгэн Хорооны удирдлагуудад танилцуулж нэгтгэлийг Зах зээлийн хөгжлийн газарт хүргүүлж байна.

2016 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэн явуулж буй 463 ББСБ байгаагийн 140 ББСБ нь буюу нийт ББСБ-ын 30.2 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Үүнээс 51 ББСБ нь зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа дагнан эрхэлж байгаа бөгөөд нийт ББСБ-ын 11 хувийг, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 140 ББСБ-ын 36.4 хувийг тус тус эзэлж байгаа бол 89 ББСБ нь банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай хавсран эрхэлж байна.

Тайлант хугацаанд гадаад валютын арилжааны мэдээг ирүүлбэл зохих нийт 140 ББСБ-ын 113 нь ирүүлж, 27 нь ирүүлээгүй бөгөөд мэдээний ирц 80.7 хувьтай байна.

Мэдээ ирүүлээгүй 27 ББСБ-ын 5 нь тайлант хугацаанд гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлээгүй гэсэн тайлбар бүхий албан бичгийг Хороонд ирүүлсэн, 2 ББСБ нь шинээр тусгай зөвшөөрөл авсан, 20 ББСБ нь ямар нэгэн тайлбар ирүүлээгүй байна.

Мэдээний ирцийг өмнөх улирлуудтай харьцуулан үзвэл:

/Хүснэгт 1/

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	Мэдээ ирүүлэх ББСБ-ын тоо	Мэдээ ирүүлсэн ББСБ-ын тоо	Мэдээний ирц	Өсөлт, бууралт хувиар /өмнөх улирлаас /
1	2012 оны 1 дүгээр улирал	91	68	74.7%	3.0%
2	2012 оны 2 дугаар улирал	91	66	72.5%	-2.2%
3	2012 оны 3 дугаар улирал	91	61	67.0%	-5.5%
4	2012 оны 4 дүгээр улирал	94	68	72.3%	5.3%
5	2013 оны 1 дүгээр улирал	98	70	71.4%	-0.9%
6	2013 оны 2 дугаар улирал	98	69	70.4%	-1%
7	2013 оны 3 дугаар улирал	99	64	67.7%	-2.33%
8	2013 оны 4 дүгээр улирал	104	74	71.2%	3.48%
9	2014 оны 1 дүгээр улирал	111	73	65.8%	-5.39%
10	2014 оны 2 дугаар улирал	118	73	61.9%	-3.86%

11	2014 оны 3 дугаар улирал	124	77	62.2%	0.3%
12	2014 оны 4 дүгээр улирал	129	80	62.0%	-0.2%
13	2015 оны 1 дүгээр улирал	135	77	57,0%	-5,0%
14	2015 оны 2 дугаар улирал	136	86	63.2%	6,2%
15	2015 оны 3 дугаар улирал	138	88	63.7%	0,5%
16	2015 оны 4 дүгээр улирал	142	87	61.3%	-2,5%
17	2016 оны 1 дүгээр улирал	140	113	80.7%	19,5%

Дээрх хүснэгтээс тайлант хугацаанд валютын арилжааны мэдээний ирцийг хувиар тооцож үзвэл:

-2012 оны 1 дүгээр улиралд 74.7%;

-2013 оны 1 дүгээр улиралд 71.4%;

-2014 оны 1 дүгээр улиралд 65.8%;

-2015 оны 1 дүгээр улиралд 57.0%;

-2016 оны 1 дүгээр улиралд 80.7% байгаа нь 2015 оны мөн үеийнхээс 23.7%-иар өссөн байна.

ХОЁР. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА БОЛОН ВАЛЮТЫН ХАНШ

ББСБ-уудаас ирүүлсэн гадаад валютын арилжааны мэдээнд үндэслэн иргэн, хуулийн этгээдээс худалдан авсан болон худалдсан гадаад валют тус бүрийн ханшийг ам.доллар болон Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгт хөрвүүлсэн дүнгээр тус тус тооцон өмнөх улиралтай харьцуулсан байдлаар гаргасан.

2.1 Гадаад валютыг худалдан авсан болон худалдсан арилжааны талаар:

Тайлант хугацаанд гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх 113 ББСБ-уудын худалдан авсан болон худалдсан валютуудын дүнг ам.доллар, төгрөгт хөрвүүлэн, өмнөх улиралтай харьцуулж үзвэл:

Худалдан авсан:


/Хүснэгт 2/

№	ВАЛЮТЫН НЭР	Улирал					
		2013.1	2014.1	Өөрчлөлт	2015.1	2016.1	Өөрчлөлт
				/+;-/			/+;-/
1	Төгрөгт шилжүүлсэн /мянган төгрөгөөр/	232,589,721.4	235,176,339.9	2,586,618.5	193,526,327.2	190,509,280.1	-3,017,047.1
2	Ам.долларт шилжүүлсэн /мянган ам.доллар/	166,648.2	181,360.9	14,712.7	99,059.1	93,495.7	-5,563.4
3	ДУНДАЖ ХАНШ	1,395.7	1,696.2	300.5	1,953.7	2,037.63	85.9

Тайлант улиралд худалдан авсан нийт гадаад валютуудын дүнг төгрөгт хөрвүүлэн, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 3,017,047.1 мянган төгрөгөөр буюу 1,6 хувиар, ам.долларт хөрвүүлсэн дүнгээр 5,563.4 мянган ам.доллараар буюу 5.6 хувиар тус тус буурсан байна.

Худалдан авсан валютуудыг төгрөгт шилжүүлснээр /мян.төг/:

/График1/




Худалдсан:

/Хүснэгт 3/

№	ВАЛЮТЫН НЭР	Улирал					
		2013.1	2014.1	Өөрчлөлт	2015.1	2016.1	Өөрчлөлт
				/+;-/			/+;-/
1	Төгрөгт шилжүүлсэн /мянган төгрөгөөр/	248,997,043.6	228,652,873.2	-20,344,170.0	203,345,024.9	201,824,657.1	-1,769,561.4
2	Ам.долларт шилжүүлсэн /мянган ам.доллар/	177,734.3	130,856.5	-46,877.8	103,716.9	99,097.4	-4,741.9
3	ДУНДАЖ ХАНШ	1,401.0	1,747.4	346.4	1,960.6	2,036.6	76.0

Худалдсан валютуудыг төгрөгт шилжүүлснээр /мян.төг/:

/График 2/




Худалдсан нийт гадаад валютуудын хувьд өмнөх улиралтай харьцуулахад 1,769,561.4 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар, ам.долларт хөрвүүлсэн дүнгээр 4,741.9 мянган ам.доллараар буюу 4.8 хувиар тус тус буурсан байна.

ББСБ-уудын 2016 оны 1 дүгээр улиралд худалдсан нийт гадаад валют болон худалдан авсан нийт гадаад валютуудын дүнг төгрөгт шилжүүлснээр /190,509,280.1₮-201,824,657.1₮/ - 113,153.8 мянган төгрөг буюу нийт арилжааны үнийн дүнгийн 0.03 хувийг, ам.долларт хөрвүүлснээр /93,495.7\$-99,097.4\$/ -5,601.7 мянган ам.доллар буюу нийт арилжааны үнийн дүнгийн 2.9 хувийг тус тус эзэлж байна.Өөрөөр хэлбэл, тайлант хугацаанд ББСБ-уудаас валютын зах зээлд нийлүүлэх гадаад валютын нийлүүлэлтийн хэмжээ өссөн байна. Нэгтгэлийн дүнгээр худалдан авсан нийт валютын 13.3 хувийг хуулийн этгээдээс, 86.7 хувийг иргэдээс худалдан авсан, худалдсан нийт валютын 9.7 хувийг хуулийн этгээдэд, 90.3 хувийг иргэдэд худалдсан байх ба энэ нь ББСБ-уудын гадаад валютын арилжаанд ихэвчлэн иргэд үйлчлүүлсэн болохыг харуулж байна.


Хуулийн этгээдээс худалдан авсан валютуудын дүн /мянгачилсан дүнгээр/:

/График 3/




Хуулийн этгээдэд худалдсан валютуудын дүн /мянгачилсан дүнгээр/:

/График 4/




Иргэдээс худалдан авсан валютуудын дүн /мянгачилсан дүнгээр/:

/График 5/



Иргэдэд худалдсан валютуудын дүн /мянгачилсан дүнгээр/:

/График 6/




2.2 Валютын ханшны талаар:

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх 113 ББСБ-ын худалдан авсан болон худалдсан нийт валют тус бүрийн дундаж ханшийг харуулбал:


Гадаад валютуудыг худалдан авсан дундаж ханш:

/График 7/



Гадаад валютуудыг худалдсан дундаж ханш:

/График 8/



ББСБ-уудын гадаад валютын арилжаанд түгээмэл ордог гадаад валютуудын зах зээл дэх ханшийн өөрчлөлт /хэлбэлзэл/-ийг үзүүлбэл:

/төгрөгөөр/

/Хүснэгт 4/

№	Валютын төрөл	Худалдаж авсан дундаж ханш					
		2013 оны 1-р улирал	2014 оны 1-р улирал	Өсөлт, бууралт /+;- / /өмнөх үеэс/	2015 оны 1-р улирал	2016 оны 1-р улирал	Өсөлт, бууралт /+;- / /өмнөх үеэс/
1	АНУ доллар	1,395.7	1,737.2	341.5	1,953.6	2,037.6	84.0
2	Евро	1,823.5	2,391.8	568.3	2,206.6	2,233.1	43.0
3	БНХАУ-ын юань	223.8	285.6	61.8	311.1	310.1	-1.0
4	ОХУ-ын рубль	45.4	49.2	3.8	34.4	27.9	-6.5
5	Японы иен	16.0	17.0	1.0	16.4	17.3	0.9

/төгрөгөөр/

/Хүснэгт 5/


№	Валютын төрөл	Худалдсан дундаж ханш					
		2013 оны 1-р улирал	2014 оны 1-р улирал	Өсөлт, бууралт /+;- / /өмнөх үеэс/	2015 оны 1-р улирал	2016 оны 1-р улирал	Өсөлт, бууралт /+;- / /өмнөх үеэс/
1	АНУ доллар	1,401.0	1,747.4	346.4	1,960.7	2,036.6	75.9
2	Евро	1,849.7	2,412.1	562.4	2,224.4	2,242.2	17.8
3	БНХАУ-ын юань	225.4	287.8	62.4	313.0	312.1	-0.9
4	ОХУ-ын рубль	46.1	50.1	4.0	35.4	28.1	-7.3
5	Японы иен	15.5	17.2	1.7	16.6	17.6	1.0

Гадаад валютын арилжааны мэдээний нэгтгэлээс үзэхэд тайлант хугацаанд нийт 392,333,937.1 мянган төгрөг буюу 192,593.1 мянган ам.долларын арилжаа хийсний 168,112,562.3 мянган

төгрөг буюу 82,524.5 мянган ам.доллар нь нийт арилжааны 43.8 хувийг, 27,675,609.9 мянган төгрөг буюу 13,585.5 мянган ам.долларын евро нь нийт арилжааны 4.6 хувийг, 151,612,575.1 мянган төгрөг буюу 74,426.1 мянган ам.долларын юань нь нийт арилжааны 46.2 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 5.4 хувийг бусад валют эзэлж байна

Нийт гадаад валютуудын арилжаанд тухайн валютын эзлэх хувь:

/График 9/



2.3. Гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ-уудын санхүүгийн тайлангийн товч үзүүлэлтийн талаар:

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 463 ББСБ байгаагийн 140 ББСБ буюу 30.2 хувь нь гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагийн дотор 51 ББСБ нь гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхлэх зөвшөөрөлтэй байна. Тэдгээрийн нийт актив нь салбарын активын 50.4 хувийг, нийт эзэмшигчдийн өмч нь салбарын эзэмшигчдийн өмчийн 45.0 хувийг, хувь нийлүүлсэн хөрөнгө нь салбарын хувь нийлүүлсэн хөрөнгийн 40.9 хувийг тус тус эзэлж байна.

Гадаад валютын арилжаа эрхэлдэг ББСБ-уудын 2016 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн товч үзүүлэлт /мянган төгрөгөөр/:

/Хүснэгт 6/

№	Үндсэн үзүүлэлтүүд	Зөвхөн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй ББСБ-ууд	Гадаад валютын арилжааны үйл ажиллагааг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай давхар эрхлэх зөвшөөрөлтэй ББСБ-ууд	Нийт гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ууд
	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	51	89	140
	ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	11.02%	19.22%	30.24%
A	Нийт актив	11,145,404.05	308,491,633.94	319,637,037.99
	ББСБ-ын нийт активт эзлэх хувь	1.74%	30.60%	32.34%

Б	Нийт эзэмшигчдийн өмч	11,048,988.34	194,046,436.33	205,095,424.67
	ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь	2.43%	42.59%	45.02%
В	Хувь нийлүүлсэн хөрөнгө	10,530,076.40	129,151,625.34	139,681,701.74
	ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь	3.09%	37.85%	40.93%
Г	Нийт орлого	315,788.52	21,684,999.30	22,000,787.82
Д	Нийт зарлага	319,361.87	15,580,920.72	15,900,282.59
Е	Ашиг/алдагдал	-3,573.35	6,104,078.58	6,100,505.23

ГУРАВ. САНАЛ, ДҮГНЭЛТ

Тайлант хугацаанд гадаад валютын арилжааны мэдээ ирүүлбэл зохих нийт 140 ББСБ-аас 113 ББСБ нь мэдээгээ ирүүлсэн байна. Мэдээний ирц 80.7 хувьтай байгаа нь өмнөх онуудтай харьцуулахад ББСБ-ууд тогтмол мэдээгээ ирүүлж хэвшиж байгаа сайн үр дүн харагдаж байна.

Мэдээ ирүүлээгүй 27 ББСБ-ын 5 нь тайлант хугацаанд энэхүү үйл ажиллагааг эрхлэн явуулаагүй, цаашид явуулна гэсэн тайлбар бүхий албан бичгийг Хороонд ирүүлсэн бөгөөд 2 ББСБ нь шинээр тусгай зөвшөөрөл авсан, 20 ББСБ нь ямар нэгэн тайлбар ирүүлээгүй байна.

Гадаад валютын арилжааны мэдээ огт ирүүлээгүй ББСБ-уудад газар дээрх үзлэг, шалгалтыг хийж, “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 7.1, 7.7-д заасны дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ууд нь гадаад валютын ханшийн зөрүүн дээр ашиг олох зорилготой байдаг тул ББСБ-уудын мөнгөн хөрөнгө нь зах зээл дээрх валютын эрэлт хэрэгцээтэй уялдан өдөрт хэдэн ч удаа эргэлтэд орох боломжтой байгаатул гадаад валютын худалдсан болон худалдан авсан мөнгөний дүн өндөрөөр илэрхийлэгдсэн байна.

2016 оны 1 дүгээр улирлынбайдлаар худалдан авсан болон худалдсан нийт гадаад валютуудын хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдан авсан, худалдсан валют нь төгрөгөөр болон ам.доллороор буурсан дүнтэй байна.

Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэн явуулдаг ББСБ-ууд нь бэлэн мөнгөөр арилжаа хийдэг учраас гадаад валютын арилжааны мэдээг бүх ББСБ-уудаар сар бүр, бүрэн гаргуулан авч, нэгтгэлд хамруулж байх нь зах зээл дээр эргэлдэж буй бэлэн мөнгөний тоо хэмжээг тодорхойлоход гаргахад чухал ач холбогдолтой.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР